



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 0/69

Улаанбаатар хот

Өндөржүүлсэн бэлэн байдалд
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.4, Засгийн газрын 2024 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол орны нийт нутаг дэвсгэрт өвөлжилт, хаваржилт хүндэрч байгаатай холбогдуулан бэлэн байдлыг хангах зорилгоор 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд эрүүл мэндийн салбарыг өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлсүгэй.

2. Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлсэнтэй холбогдуулан эрүүл мэндийн байгууллагын өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах түр журмыг хавсралтаар баталсугай.

3. Малчид, иргэдэд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх, шаардлагатай тохиолдолд орон нутагт ажиллуулах хөтөлбөр бүхий баг томилох, эмнэлгийн ажилчдыг мэргэжил арга зүйгээр ханган, сургалт зохион байгуулж ажиллахыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв /В.Баярмаа/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж, мөрдөж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захиралт нарт үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэрт даалгасугай.

САЙД  С.ЧИНЗОРИГ



Эрүүл мэндийн сайдын 2024 оны 02
дугаар сарын 12-ны өдрийн 62 дугаар
тушаалын хавсралт

ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАХ ТҮР ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.1-10.4.5, 11 дүгээр зүйлийн 11.3.4, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилгоор эрүүл мэндийн байгууллагуудыг өндөржүүлсэн бэлэн байдлын горимд шилжин ажиллах харилцааг энэхүү түр журмаар зохицуулна.

1.2. Эрүүл мэндийн байгууллага нь энэхүү горимыг үндэслэн байгууллагын үйл ажиллагааны онцлог, чиг үүрэгтэй нийцүүлэн өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах төлөвлөгөө батлан, хэрэгжүүлж ажиллах бөгөөд энэ нь тухайн байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг байна.

Хоёр. Хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл

2.1. Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн талаар байгууллагын ажилтан албан хаагчдад танилцуулан, үүрэг чиглэл өгч, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

2.2. Өндөржүүлсэн бэлэн байдалд эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, ажиллах хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуур, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, хүчилтөрөгчийн хангамж, унаа шатахууны нөөцийг бүрдүүлэх;

2.3. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед гарсан шийдвэр, үүрэг чиглэлийг тухай бүрт хэрэгжүүлж ажиллах;

2.4. Бүх шатны эрүүл мэндийн байгууллага бүр бэлэн байдлын тусгай горимд шилжин, цагийн хуваарийн дагуу ажиллах;

2.5. Аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар болон Ус цаг уурын албанаас цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг тогтмол авч, эрсдэлийн үнэлгээг үндэслэн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.6. Ажилтан албан хаагчдын ажил, үүрэг гүйцэтгэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх, хоол хүнс, хувцас, техник хэрэгслээр хангах, аюулгүй ажиллагааг сахиулах, эрүүл мэндэд анхаарч ажиллах;

2.7. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тасралтгүй бэлэн байдлыг хангаж, бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх;

2.8. Өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах дадлага, сургалтыг зохион байгуулж, ажилтан, албан хаагчдыг бүрэн хамруулах;

2.9. Байгууллага, салбар, нэгжийн хэмжээнд ажиллах шуурхай штаб, эргүүл, жижүүрийг томилон удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах;

2.10. Отроор өвөлжиж буй эрсдэлт бүлгийн хүн амын судалгааг 14 хоног тутамд шинэчлэн нягталж, Эрүүл мэндийн яаманд ирүүлэх;

2.11. Эрүүл мэндийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/418 дугаар тушаалын гурав, дөрөвдүгээр хавсралт болон 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/309 дугаар тушаалын дагуу Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны үйл ажиллагааг идэвхжүүлэн ажиллах;

- 2.12 Гамшиг тохиолдсон үед сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх баг байгуулж, малчид иргэдэд сэтгэлзүйн зөвлөгөө, тусламж үзүүлэх;
- 2.13.Зудтай холбоотой хорогдсон малын сэг зэмээс үүдэлтэй халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг эрчимжүүлэх;
- 2.14. Нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Эрүүл мэндийн яаманд тухай бүрт шуурхай танилцуулах;
- 2.15. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажиллаж байгаа тайланг долоо хоног бүрийн баасан гарагийн 17.30 цагаас өмнө Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газарт бичгээр болон цахимаар ирүүлэх.

Гурав. Бусад

- 3.1. Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн үеийн зохион байгуулалтын арга хэмжээ, эрх, үүргийг зөрчсөн ажилтан, албан хаагчдыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---ooOoo---